



МОНГОЛ
УЛСЫН
ХӨРӨНД

ШИВЭЭЭГОВЬ СУМЫН МЭДЭЭ



2024 оны 04-р сарын 27-ноос 2024 оны 05-р сарын
10-ны хооронд хийгдсэн ажлуудаас



МОНГОЛ
УЛАСЫН
ХАМГААГАХ
ЯРИЙ

Аймгийн Онцгой байдлын газраас “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт бэлдэх” журмын дагуу шалгалтыг суманд 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан бөгөөд сумын шуурхай штабын ажлын үйл явц, сумын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлэн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, сайжруулалт хийх мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаад байна. Тус бэлэн байдлын шалгалтын дагуу 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр онцгой байдлын 28 нэр төрлийн тайланг бэлтгэж хүргүүлэхээр ажиллаж байна.





Хөгжлийн үндэс

#Татвар төлөгчдийн өдрийг

тохиолдуулан аймгийн Татварын газар сумын ЗДТГазартай хамтран 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр сумын Засаг даргын Тамгын газарт иргэдэд мэдээлэл хүргэн ажиллалаа. Тус өдөрлөгөөр сумын аж ахуйн нэгжүүдэд болон иргэдэд татварын мэдээ мэдээлэл хүргэж, татвар төлөгчдөд зөвөлгөө мэдээлэл өгч ажиллав. Мөн сумын ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад "Татвар хөгжлийн үндэс" сэдэвт гар зургийн уралдаанд орлцсонд талархал гардууллаа.



Говьсүмбэр аймгийн татварын газар



Говьсүмбэр аймгийн татварын газар



Хөдөө аж ахуйн талаар

Сумын хэмжээнд 05-р сарын 10-ны байдлаар 14897 мал хорогдоод байна. Үүнд: Адуу-1152, Үхэр-909, Тэмээ-1, Хонь-7368, Ямаа-5467 хорогдоод байна.

Төлийн мэдээ: Ботго-1, Унага-24, Тугал-72, Хурга-2718, Ишиг-2111 Нийт-4926 төл гараад байна.

Үүнээс хорогдол: Ботго-0, Унага-9, Тугал-31, Хурга-1066, Ишиг-1282 Нийт-2388 хорогдож,

Бойжилт: Ботго-1, Унага-15, Тугал-41, Хурга-1652, Ишиг-829 Нийт-2538 төл бойжиж, бойжилтын хувь 63.9%-тай байна.





ᠮᠤᠩᠭᠡᠯᠢ
ᠮᠤᠯᠠᠭ
ᠤᠯᠤᠰ

Хөдөө аж ахуйн талаар

2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Өмнөговь аймагт зохион байгуулагдсан “Шинэ хоршоо” хөдөлгөөний нээлт болох бүсийн чуулга уулзалтад сумаас Засаг даргаар ахлуулсан 20 малчин иргэний бүрэлдэхүүнтэй малчдын төлөөлөл тус чуулга уулзалтад оролцлоо.





Хэвлэл мэдээллийн чиглэлээр

Өнгөрсөн 14 хоногийн байдлаар “Шивээговь сум мэдээ” цахим хуудсанд нийт 37 мэдээ мэдээлэл байршуулснаас 11 мэдээг байгууллагаас бэлтгэн байршуулж, 26 мэдээг бусад байгууллагаас шэйрлэж мэдээллэсэн байна.

Нэг цэгийн үйлчилгээг операторын горимд шилжүүлснээр e-mongolia цахим системээс 2024 оны 04-р сарын 27-ноос 2024 оны 05-р сарын 10-ны байдлаар нийт 22 лавлагааг иргэдэд үзүүлсэн байна. Үүнд:



ᠬᠡᠪᠯᠡᠯᠢ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠢ ᠵᠢᠭᠯᠡᠯᠡᠭᠡᠷ

№	Үйлчилгээний нэр	Үйлчилгээний тоо
1	Иргэний үнэмлэхийн лавлагаа	6
2	Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа	4
3	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт	4
4	Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт	3
5	Зээлийн мэдээллийн лавлагаа	2
6	Гэрлэсний бүртгэлийн лавлагаа	2
7	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт	1
Нийт - 22		



ᠮᠤᠨ
ᠬᠥᠳᠥᠯᠮᠥᠷ
ᠶᠡᠯᠠᠮᠵᠢ
ᠵᠢᠯᠠᠭᠠᠨ
ᠴᠢᠭᠯᠡᠯᠡᠭᠡᠷ

Хөдөлмөр, халамж үйлчилгээний чиглэлээр

2024 оны 04-р сарын 13-наас 2024 оны 04-р сарын 26-ны байдлаар хөдөлмөр эрхлэлт болон халамжийн үйлчилгээг нийт 28 иргэнд хүргэж ажиллаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 22 иргэнд, нийгмийн халамжийн 4 төрлийн үйлчилгээг 6 иргэнд хүргэсэн. Үүнд:

1. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн данс солих үйлчилгээ-1
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр сунгалт-1
3. Амралтын эрхийн бичиг 3
4. Алхуулагч хөнгөлөлт 1 иргэнд тус тус хүргэж ажилласан байна.

Мөн Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн 4 төрлийн төсөл арга хэмжээний төсөл болон Нийгмийн халамжийн хэлтсийн Олон нийтийн оролцооны бүлгийн төсөл хүлээн авч байна. Эхний байдлаар 6 иргэн, 1 байгууллагын төсөл хүлээж авсан бөгөөд төслийн талаар иргэдэд тогтмол мэдээлэл өгч ажиллаж байна.




Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны чиглэлээр

ᠣᠨᠬᠤᠰ-ийн хөрөнгөөр хийгдэх Төрийн байгууллагуудын шаардлагатай техник тоног төхөөрөмж худалдаж авах ажлын нийлүүлэгчээр шалгарсан компанитай гэрээ хийсэн. 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр гэрээнд заагдсан хугацаагаар гэрээг дүгнэж, техник тоног төхөөрөмжийг хүлээн авахаар ажиллаж байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх Төрийн байгууллагуудын шаардлагатай техник тоног төхөөрөмж худалдаж авах ажлын нийлүүлэгчээр шалгарсан компанитай гэрээ хийсэн. 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр гэрээнд заагдсан хугацаагаар гэрээг дүгнэж, техник тоног төхөөрөмжийг хүлээн авахаар ажиллаж байна.

Өнгөрсөн 14 хоногийн байдлаар ОНХС-аар батлагдсан 12 ажлын даалгавраас 6 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан. Үүнд:

- Төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцлийг дэмжих /байр засварлах/ ажил
- Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах ажил
- Ёслол хүндэтгэлийн өргөө гэр авах
- Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засвар үйлчилгээний ажил.
- Сургуулийн спорт заалны их засвар
- Хуучин хог хаягдал булшлах, шинээр хогийн цэг байгуулах ажлуудын тендерийг зарлаад байна.





ТӨСВИЙН
СЭВ

Санхүү албаны цаг үеийн мэдээ

Орон нутгийн татварын орлого 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 16 төрлийн татварын орлого гүйцэтгэлээр 890,630,311.55 төгрөг бүрдэж, биелэлтээр 120.02%-ийн давсан үзүүлэлттэй бүрдсэн байна.

Шивээговь сумын орон нутгийн татварын орлого						
Татварын төрлийн нэр	Төрийн сангийн данс	Жилийн батлагдсан төлөвлөгөө	Өссөн дүнгээр			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Газрын төлбөр	100220300943	172,000,000	43,000,000	12,816,355.00	30,183,645.00	29.81
Газрын үл хөдлөх эд хөрөнгийн АТ	100220300923	-	-	8,246.00	(8,246.00)	#DIV/0!
Иргэний ҮХЭХАТ	100220300924	-	-	384,000.00	(384,000.00)	#DIV/0!
Галт зэвсгийн албан татвар	100220300922	1,070,000	-	-	-	#DIV/0!
Иргэний үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогоос суутгасан албан татвар	100220300962	25,000,000	6,600,000	3,460,000.00	3,140,000.00	52.42
Малын тоо толгойн албан татвар	100220300917	45,000,000	-	2,393,100.00	(2,393,100.00)	#DIV/0!
Иргэний эрх борлуулсны орлого	100220300916	-	-	20,800.00	(20,800.00)	#DIV/0!
Хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар	100220300975	28,000,000	8,800,000	16,971,430.00	(8,171,430.00)	192.86
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	100220300948	15,000,000	-	-	-	#DIV/0!
Улсын тэмдэгтийн хураамж	100220300941	3,500,000	1,000,000	500,000	500,000.00	50.00
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	100220300947	18,000,000	6,000,000	2,579,000.00	3,421,000.00	42.98
Хувь хүний орлогын албан татвар	100220300911	3,500,000	1,160,000	4,820,879.00	(3,660,879.00)	415.59
Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар	100220300901	1,784,520,500	684,000,000	678,834,167.00	5,165,833.00	99.24
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	100220300921	320,000,000	80,000,000	50,292,338.55	29,707,661.45	62.87
Суутгагчийн ХХ-д олгосон ОАТ / шууд бус орлого/	100220300912	6,000,000	1,500,000	117,549,996.00	(116,049,996.00)	7,836.67
Хувь хүний ОАТ-ын буцаан олголт	100220300912	(90,000,000)	(90,000,000)	-	(90,000,000.00)	-
Нийт дүн		2,331,590,500	742,060,000	890,630,311.55	(148,570,311.55)	120.02



МОНГОЛЫН
УЛАМГАЙН
ХАМГААГАХ
МОНГОЛ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

